

Бие даан ажиллах бодлого, дасгал

Бодлого 1. А группын 11 сурагчийн математикийн хичээлийн шалгалтын дүнгийн мэдээлэл 70, 75, 80, 80, 80, 85, 88, 90, 90, 92, 95 гэж өгөгдөв. Уг өгөгдлийн хувьд доод квартил, медиан болон дээд квартилын утгыг тус, тус ол.

/ Хариу $Q_1 = 80, Me = 85, Q_3 = 90$ /

Бодлого 2. Төслийн баг таван хүний бүрэлдэхүүнтэй. Уг төслийн багийн гишүүдийн нэг цагийн цалингийн хэмжээг судлахад \$8, 10, 10, 10, 12 байсан бол стандарт хазайлтыг ол.

/ Хариу \$1.41 /

Бодлого 3. Дэлгүүрээр үйлчлүүлж буй хэрэглэгчдийн тоог өнгөрсөн 30 өдрийн турш судлахад дараах үр дүн гарав.

83	64	84	76	84	54	75	56	70	61	63	80	84	73	68
52	65	90	52	77	95	36	78	61	59	84	95	47	87	60

Уг өгөгдлийг хувьд 25-р перцентил, медиан болон дээд квартилын утгыг ол.

/ Хариу $P_{25} = Q_1 = 59.75, Me = 71.5, Q_3 = 84$ /

Бодлого 4. Авто тээвэр эрхэлдэг нэгэн компаний авто машины нэг сард гүйцэтгэсэн тээвэрлэлтийн талаар дараах мэдээлэл өгөгдөв.

Чиглэлийн ирэх, очих зай /км/	Өдөрт явсан ресийн тоо
30-50	15
50-70	20
70-90	14
90-110	18
110-130	9
130-150	6

Хийх зүйл:

- Дундаж болон стандарт хазайлтыг тооц.
- Медиан, дээд квартилын утгыг ол.

/ Хариу $\bar{X} = 81, C.X = 30.27, Me = 78.57, Q_3 = 103.89$ /